

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын
2011 оны 256 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН ДҮРЭМ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРОН ЗАЙ, ОРЧНЫ ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОХ ДҮРЭМ

2011 оны дугаар сарын-ний
өдрөөс эхлэн мөрдөнө.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хэрэглэх хүрээ

1.1.1 Энэхүү дүрмийг хөгжийн бэрхшээлтэй иргэдэд зориулан орон сууц, олон нийтийн барилгын төлөвлөлт, хот суурийн газрын орон зай, орчинг тэдгээрийн шаардлагад тооцож зураг төсөл боловсруулахад зөвлөмжийн чанартай мөрдөнө.

1.1.2 Дүрмийн үндсэн хэсэг нь хөдөлгөөний болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан болно.

1.1.3 Дүрэмд сэтгэцийн болон оюун ухааны хомсдолын хөнгөн хэлбэртэй, дотоод эрхтэний өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон, өндөр настай иргэдийн хэрэгцээг тооцсон болно.

1.2. Иш татсан баримт бичгүүд

-БНБД 31-01-01 Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм

-БД 31-101-04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль

-MNS 5611:2006 Орон сууцны барилгад тавигдах үндсэн шаардлага

-MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци. 2007 он.

-Americans with Disabilities Act /Access Guide: Survey Checklist/

1.3. Нэр томьёо

Энэхүү дүрэмд хэрэглэх нэр томьёог дараах утгаар ойлгоно. ("Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" /MNS 6055:2009/-ээс).

1.3.1. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

урт хугацааны бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой бөгөөд энэ бэрхшээл нь орчны бусад хязгаарлалттай нэгдэн нийлж бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүмүүс

1.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүн

эрүүл мэндийн хувьд төрөлхийн согогтой, биеийн үйл ажиллагаа, тэсвэр хатуужил муудаж доройтсон буюу өвчилсөн эсвэл бэртэж гэмтсэн, хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсан, амьдралын хүнд бэрхшээлд орсон хүн

1.3.3. хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүс

ихэвчлэн 60 ба түүнээс дээш өндөр настай хүмүүс, 16-аас 60 насны хөдөлмөрийн чадвартай тахир дутуу, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхэд, түр зуурын хөдөлмөрийн чадваргүй, хүүхдийн тэргэнцэр хэрэглэдэг 8-10 насны хүүхэд багтана

1.3.4. налуу зам

босоо чиглэлд барилгын гадна дотно хэсгийг холбосон налуу хавтгай

1.3.5. бүсчлэл ба орон зай

хэмжигдэхүүний тоон утга (урт, өргөн, өндөр) - Орон зай болон байгуулалт дээр ямар нэг юмны хоорондох хязгаарлалтыг заасан хэмжээ. (Жишээлбэл: хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх орон зайн өргөн, урт, тэргэнцрийн эргэх радиус, хүрч болох өндрийн хэмжээ г.м.)

1.3.6. үйл ажиллагаа-зориулалтын бүс

ямар нэг үйл ажиллагаатай холбогдсон орчны хязгаарлалтын шинж чанарыг тодорхой харуулсан орон зай. Жишээ нь: автомат-харилцуур утасны дэргэдэх орон зай, ширээ болон лангууны ойролцоох бүсчлэлийн орон зай г.м.

1.3.7. орон сууц

хүн байнга буюу түр оршин суух зориулалттай нэг ба олон айлын сууцны байшин

Хоёр. ХҮН АМ ОРШИН СУУХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

2.1. Ерөнхий шаардлага

2.1.1. Хүн амын оршин суух хот суурин газрын зураг төслийг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, тэдний тусгай хэрэгцээнд нийцэх нөхцлийг бүрдүүлэх.

2.1.2. Хот суурин газар болон орон сууцны дүүрэг түүний гудамж замын сүлжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан нийтийн тээвэрт суухад тохиромжтой талбай болон явган хүний замыг зураг төсөлд тусгана.

2.1.3. Тэргэнцэртэй иргэнд зориулсан барилга байгууламж, орон сууцны барилгыг (өдөр тутам үйлчлүүлдэг) худалдааны төв, дэлгүүр, ахуйн иж бүрэн үйлчилгээний төвөөс 300 м-ээс холгүй газар байршуулах хэрэгтэй.

2.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орон сууцны барилга болон хүүхдийн байгууллагыг гал унтраах цэгээс 3000 м-ээс багагүй зайд байрлуулна.

2.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан байгууллагыг үйлдвэрийн газар, авто машины хөдөлгөөн ихтэй гудамж, зам, төмөр зам түүнчлэн чимээ шуугиан ихтэй, агаар хөрсний бохирдолтой газраас 3000 м-ээс багагүй зайд ногоон байгууламж бүхий газарт төлөвлөнө. Хараа болон сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургуулийг радиостанц, радио релейны байгууламжаас 1500 м-ээс багагүй зайд байрлуулна.

2.2. Нутаг дэвсгэрийн хэмжээ

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэдэд зориулсан асрамжийн байр, орон нутгийн нийгмийн үйлчилгээний төвийн талбайг хүснэгт 1-ээс, хүүхдийн байгууллагын эдэлбэр газрын талбайн хэмжээг хүснэгт 2-оос тус тус авна.

2.2.2. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан байгууллагын эдэлбэр газрын талбайг 1 хүнд 60 м² аас багагүй байхаар тооцно.

Хүснэгт 1

Барилгын төрөл	Багтаамж , (хүнээр)	1 хүнд ноогдох эдэлбэр газрын талбай, м ²
Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэний асрамжийн байр	50 хүртэл	200
	51-100	175
	101-200	125
	201-300	100
Олон нийтийн үйлчилгээний төвүүд	50 хүртэл	150
	51-75	125
	76-100	100

Тайлбар: Хотын захын бүсэд, ногоон байгууламжид ойр төлөвлөх асрамжийн байрны эдэлбэр газрын талбайг 20%-иар багасган төлөвлөхийг зөвшөөрнө.

Хүснэгт 2

Зэргэлдээх ангийн тоо	Тусгай сургууль, дотуур байрны 1 сурагчид ногдох эдэлбэр газрын талбайн хэмжээ, м ²				Нуруу нугасны ба мэдрэлийн өвчтэй
	Хөгжлийн бэрхшээлтэй				
	сонсгол	хараа	оюун ухаан		
1	200	205	225	180	
2	160	160	180	140	

Тайлбар: Оюун ухааны хомсдолтой хүүхдэд зориулсан асрамжийн байрны эдэлбэр газрын талбайн хэмжээг 15%-иар багасган төлөвлөхийг зөвшөөрнө.

2.2.3. Оюун ухааны хомсдолтой хүүхдүүдэд зориулсан асрамжийн байрны эдэлбэр газрын талбайн хэмжээг хүснэгт 3-ын дагуу тооцно.

Хүснэгт 3

1 сурагчид ногдох эдэлбэр газрын талбай, м ²			
Суралцдаг хүүхдүүдийн хувьд		Суралцдаггүй хүүхдүүдийн хувьд	
Хөдөлж явах чадвартай	Хөдөлж явах чадваргүй	Хөдөлж явах чадвартай	Хөдөлж явах чадваргүй
100	120	80	50

2.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх насны болон оюун ухааны хомсдолтой хүүхдэд зориулсан асрамжийн байрны талбайг хүйтэн сэрүүн цаг уурын

бүсчлэл бүхий газраас бусад газарт (сургалт туршилтын талбайг оролцуулан) 1 хүүхдэд 0.6 м² –аас багагүй талбай байхаар тооцно.

2.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургууль болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настанд зориулсан асрамжийн байрны эдэлбэр газрыг 1.6 м-ээс багагүй өндөртэй хашаагаар хүрээлэгдсэн байх ба сэтгэцийн болон оюун ухааны хомсдолтой хүүхдэд зориулсан асрамжийн байрны хашааны өндөр 2 м-ээс багагүй байна.

Гурав. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОРЧНЫ ҮНДСЭН ЭЛЕМЕНТ

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зай хэмжээ

3.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэргэнцрийг байрлуулах талбайн өргөн нь 0.9 м; урт нь 1.5 м-ээс багагүй байна.

3.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих замын өргөн нэг талын хөдөлгөөнтэй үед 1.2 м-ээс багагүй, хоёр талын хөдөлгөөнтэй үед 1.8 м-ээс багагүй байна.

3.1.3. Нэвтрэх хаалганы өндөр 2.1 м-ээс багагүй байна.

3.1.4. Тэргэнцрийг 90 градуст эргүүлэх талбай 1.3x1.4 м; 180 градуст 1.3x1.7 м; 360 градуст 1.5x1.7 м-ээс багагүй байна. Барилгын тодорхой нэг хэсэг, элементүүдийн доорх орон зай, тэргэнцэртэй хүний ашиглахад тохиромжтой байх тоног төхөөрөмж, шүүгээний өргөн 0,6 м-ээс багагүй, өндөр нь шал болон явган хүний замын түвшингээс 0,6 м-ээс багагүй байна. Тоноглол болон тавилга руу очих замын өргөн 0,9 м-ээс багагүй, тэргэнцэртэй 90 градуст эргэх тохиолдолд 1.2 м-ээс багагүй талбай төлөвлөнө.

3.1.5. Барилга байгууламжийн хананд байрлуулсан тоноглол, шуудангийн хайрцаг, харилцах утасны мэдээллийн самбар гэх мэт ил гарсан хэсгүүд нь хөгжлийн бэрхшээлтэй болон тэргэнцэртэй иргэдийн явах, эргэлт хийх зам талбайд саад учруулхааргүй байна. Барилга байгууламжийн ил гарсан хэсгүүдийн доод ирмэг нь явган хүний замын гадаргуугаас 0.7-2.1 метрийн түвшинд байрлаж байгаа тохиолдолд барилгын үндсэн даацын болон хананы гадаргуугаас 0.1 м-ээс ихгүй байх ба харин тусгай тулгууртай тохиолдолд 0.3 м-ээс ихгүй байна. Энэ хэмжээнээс их гарсан тохиолдолд өнгийж гарсан хэсгүүдийн доорх зай нь 3 см-ээс багагүй өндөртэй хашлагаар тусгаарлагдсан байна.

3.2. Явган хүний зам

3.2.1. Тэргэнцэртэй болон өндөр настай иргэд явахад зориулсан явган хүний замын налуу уртаашаа 5%, хөндлөн чиглэлд 1%-иас илүүгүй байна. Газрын гадаргын нөхцлөөс хамаарч заагдсан хязгаарыг баримтлах боломжгүй бол 12 м-ээс багагүй урттай замын налууг 10%-иар нэмж болно. Тэгэхдээ уруудах замын дунд хэсэгт хэвтээ талбай төлөвлөнө.

3.2.2. Явган хүний зам гудамж замын зорчих хэсгийн огтлолцолд хэсэгт нарийн замын чулуун хашлаганы өндөр нь 2.5 см-с багагүй, 4 см-ээс өндөргүй байх хэрэгтэй. Замын хөндлөн гарцанд хурц үзүүртэй хашлага, чулууг хэрэглэх мөн оролт болон хөдөлгөөний хэсгийн өргөнийг нарийсгахийг хориглоно. Тээврийн хэрэгслийн нягтрал ихтэй газарт хамгаалах хаалтыг төлөвлөнө.

3.2.3. Гудамжны зорчих хэсэг дэх аюулгүйн зурвасыг дайран өнгөрөх явган замын өргөн нь 3 м-ээс багагүй, урт нь 2 м-ээс багагүй байна.

3.2.4. Орон сууцны бичил хороололд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явахад зориулагдсан явган хүний замын дагуу 300 м тутамд амрах сандал төлөвлөнө.

3.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг болзошгүй аюултай хэсгээс хамгаалах зорилгоор 5 см-ээс багагүй өндөртэй чулуун хашлагаар тухайн хэсгийг хашиж өгнө.

3.2.6. Аваарын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нүүлгэн шилжүүлэх гарцыг чөлөөтэй орж гархаар төлөвлөнө.

3.3. Явган хүний зам болон шал, түүний гадаргуу

3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдий амьдрах барилга байгууламжийн доторх шал, явган хүний зам нь хатуу, нягт, хальтирхааргүй хийгдсэн байна.

3.3.2. Явган хүний зам, налуу замыг хийхдээ гадаргуу нь хэт товгор, биржгэр материал ашиглахгүй байх. Бетон хавтангаар өнгөлсөн хэсэг нь тэгш, хавтангийн хоорондын зай 1.5 см-ээс ихгүй байна.

3.3.3. Хивсэнцэр дэвссэн замын уулзвар хэсгүүд ялангуяа захын ирмэг хэсэг сайтар бэхлэгдсэн байвал зохино. Хивсний зузаан 1.3 см-ээс ихгүй байна.

3.3.4. Биеийн тамирын зааланд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоглоомын болон бэлтгэл сургуулилалт хийх талбайн шалны өнгөлгөө тэгш байх ёстой.

3.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлгөөний зам дээр тавигдсан сараалжин хаалтыг хөдөлгөөний чиглэлд эгц байрлалтай сараалжууд нь бие биенээсээ 1.3 см-ээс ихгүй зайд байна.

3.3.6. Харааны бэрхшээлтэй иргэдэд ямар нэгэн саад тотгор болох шат, явган хүний гарц, аюулгүйн зурвасын төгсгөлд тулж ирж байгааг урьдчилан анхааруулах зорилгоор явган болон тэргэнцрийн зам, хучилтын гадаргуугийн үеийг өөрчилж тод ялгарах өнгө, материалаар чиглүүлэгч зурвасыг тодотгож өгнө.

3.4. Авто машины зогсоол

3.4.1. Орон сууцны хорооллын авто машины ил зогсоол, ахуйн үйлчилгээ соёлын газар, амралт сувилал, худалдааны төв, дэлгүүр, спортын байгууламж зэргийн ойролцоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто машины зогсоолыг тусгайлан төлөвлөнө. Эдгээр газарт хамгийн багадаа:

1. 100 хүртэлх машины зогсох зогсоолд 4% буюу 1-ээс багагүй
2. 101-200 хүртэл 3%
3. 201-1000 хүртэл 2%
4. 1000-аас дээш 100 машин тутамд 1%, нэмж 20 машинаас ихгүй байхаар тооцно.

3.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тусгай зориулалттай барилга байгууламжийн гадна авто машины зогсоолын талбайн 10%-иас багагүй, хөдөлгөөний болон нуруу нугасны өвчтэй иргэдийг эмчлэх эмнэлгийн ойролцоо 20%-иас багагүйг тэдэнд зориулан төлөвлөнө.

3.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто машины зогсоолыг орон сууц, олон нийтийн барилга байгууламж, ажлын байр хүртэл 50 м-ээс ихгүй зайд төлөвлөнө.

3.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн зогсоолын талбай олон нийтийн барилга байгууламжаас 100 м-т, тэдгээрийн амьдардаг орон сууцны барилга байгууламжаас 300м-т байхаар тооцно.

3.4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн авто машин зогсох зогсоолын талбайг тусгайлан тэмдэглэж таних тэмдгээр заасан байна. Зогсоолын өргөн 3.5 м-ээс багагүй байна.

3.5. Шат ба налуу зам

3.5.1. Явган хүний зам, талбайн түвшин барилга байгууламжийн шалны хоорондох уналтын зөрүү 4см-ээс их хэсэгт налуу зам, шатыг урьдчилан тооцож төлөвлөнө. Налуу замын бүтээц, тэдгээрийн хаалт хамгаалалтыг галд тэсвэртэй материалаар хийж галд тэсвэрлэлтийн хязгаар 2 цагаас багагүй байна. Зарим тохиолдолд дугуй хэлбэрийн налуу зам төлөвлөхийг зөвшөөрөх бөгөөд дотор радиусын хэмжээг хавсралт 2-т тооцсоны дагуу авна. Дугуй хэлбэртэй налуу замын завсар хоорондын талбайн урт түүний радиусаас хамаарч 2 м-ээс багагүй байна.

3.5.2. Налуу замын налууг түүний уртаас хамаарч хавсралт 1-д заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй.

3.5.3. Налуу замын өгсөлт бүрийн эхлэл төгсгөл дээр тэгш талбайг төлөвлөх ба өргөн нь налуу замын өргөнөөс багагүй, урт нь 1.5 м-ээс багагүй байна. Налуу замын чиглэлийг өөрчлөх тохиолдолд тэгш талбайн өргөн нь дугуйт тэргэнцэр эргэхэд саадгүй байна.

3.5.4. Налуу зам болон тэгш талбайн захаар 5 см-ээс багагүй өндөртэй хашлага хийх шаардлагатай.

3.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явах чигийн дагуух шатны гишгүүр нягт, тэгш, тээглэх зүйлгүй, гадаргуу нь бага зэрэг барзгар байна. Гишгүүрийн ирмэг 5 см-ээс багагүй дугуйралттай байна. Шатны гишгүүрийн захаар 2 см-ээс багагүй хашлага хийнэ. Гадна шатны гишгүүрийн өргөн 40 см-ээс багагүй, барилгын дотор шатны гишгүүрийн өргөн 30 см-ээс багагүй, гишгүүрийн өндөр гадна шатанд 12 см, дотор шатанд 15 см-ээс ихгүй байна.

3.5.6. Налуу замын 2 талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон бусад хүмүүс барьхад зориулагдсан хаалт болон бариулын дээд ирмэг хүртлэх өндөр 0.7-0.9 м-ээс багагүй байна. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд бариулын өндөр 0,5 м байна. Налуу замын эхлэл төгсгөлд бариулыг 0.3 м-ээс ихгүй илүү гаргаж төгсгөнө. Бариулын хөндлөн огтлолын диаметр 3 см-ээс багагүй 5 см-ээс ихгүй, тэгш өнцөгт огтлолтой бол зузаан нь 0.04м-ээс ихгүй байна.

3.5.7. Хоёр болон түүнээс дээш давхруудаас аврах зориулалттай налуу зам нь барилга байгууламжаас гадагшаа гарах хаалгатай шууд холбогдсон байна.

3.6. Барилга байгууламжийн орц

3.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд барилга байгууламж руу орох гархад зориулж налуу зам болон тусгай зориулалтын төхөөрөмжийг тоноглоно. Эдгээр нь барилга байгууламжийн орцонд хүргэх, нэгдүгээр давхар болон цахилгаан шатанд очих боломжоор хангана.

3.6.2. Барилга байгууламжийн орцыг цас борооноос хамгаалсан хамгаалалт болон орцын өмнөх талбайг 1х2.5 м хэмжээтэй ус зайлах (дренажийн) системийг тухайн орон нутгийн цаг агаарын нөхцөлөөс хамааруулан халаалт төлөвлөж болно.

3.6.3. Барилга байгууламж руу хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон нийтээр орох зориулсан хаалганы өргөн 0.9 м-ээс багагүй байна. Уг хаалга шилтэй байх бол цохилтонд тэсвэртэй, шил нь шалны түвшингөөс 0.9 м-т бусад хаалгын доод ирмэгийг 0,3 м хүртэл цохилтонд тэсвэртэй материалаар хамгаалсан байна. Савдаг нугастай, эргэдэг хаалга тоноглож болохгүй. Шилэн хаалга төлөвлөх тохиодолд автоматаар онгойхоор төлөвлөх ба тод өнгийн тэмдэглэгээг дээр нь хийсэн байна.

3.6.4. Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох замд босго төлөвлөхгүй ба шаардлагатай тохиолдолд босгыг 2.5 см-ээс өндөргүй төлөвлөнө.

3.6.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ороход зориулагдсан автомат ба хагас автомат шилэн хаалгыг тоноглон тохиолдолд хажууд нь энгийн хаалгыг төлөвлөх ёстой. Автомат болон хагас автомат хаалганы нээгдэх, хаагдах хугацаа 5 сек-ээс багагүй байна.

3.7. Цахилгаан шат

3.7.1. Налуу зам төлөвлөх боломжгүй тохиодолд цахилгаан шат эсвэл тусгай өргөх төхөөрөмжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэргэнцрээсээ ажиллуулах боломжтой байна.

3.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орж гарах, үйл ажиллагаа явуулдаг өрөө тасалгаа 1-ээс дээш давхарт байх бол барилгад цахилгаан шат төлөвлөх ба хүн тээх бүхээгийн өргөн 1.1 м, гүн нь 1.5 м, хаалганы өргөн 0.85 м-ээс багагүй байна. Цахилгаан шат нь давхрын түвшингээс болон бүхээгээс удирдах удирдлагатай байх ба гудамж руу шууд гарах гарцтай байна.

3.7.3. Хоёр болон түүнээс дээш давхруудад тэргэнцэртэй, хөдөлгөөний бэрхшээлтэй болон өндөр настай иргэд байнга байх өрөө тасалгаанд зориулж тэдний шаардлагыг хангасан цахилгаан шатыг тухайн барилгад төлөвлөх ба хэрэв 1-р давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр төлөвлөх боломжгүй бол 2.5-р хэсгийн шаардлагын дагуу налуу зам төлөвлөнө. Цахилгаан шатны хүн зөөвөрлөх бүхээгийн өргөн 1.1 м, гүн нь 2.2 м, цахилгаан шатны хаалганы өргөн 0.85м байна. Цахилгаан шатны ажиллах зарчим галын аюулын үед ажиллах цахилгаан шатны ажиллах зарчимтай ижил байна. Цахилгаан шатанд гал гарсан тохиолдолд угаа зайлуулах тусгай агааржуулалтын суваг байрлуулах ёстой. Суваг дахь агаарын илүүдэл даралт 20Па-аас багагүй байх ёстой. Гал гарсан тохиолдолд цахилгаан шатны ажиллагаа түүний бүх систем 2 цагийн турш тасралтгүй хэвийн ажиллаж байхаар 1-р зэргийн найдвартай ангиллын шаардлагаар хангасан байна.

3.7.4. Цахилгаан шатны гарах гарцыг 1-р давхарт үүдний хонгил ба хөлийн өрөө рүү шууд гарахаар төлөвлөнө. Цахилгаан шатны хонгил нь галд тэсвэртэй тусгаарлагч хана ба хаалгаар зааглагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахилгаан шатны хонгилыг шат хоорондын талбайд төлөвлөхийг хориглоно.

3.7.5. Цахилгаан шатны шал, барилгын шалны хоорондох түвшний зөрүү 2.5 см-ээс ихгүй байна.

3.7.6. Цахилгаан шат нь газар доорх давхар (подваль) болон газар дээрх давхар (цоколь)-тай шууд харьцахгүй. Харин цахилгаан шатны өмнө уснаас хамгаалагдсан тусгай төхөөрөмж тавьж өгсөн тохиолдолд аль нэгийг нь зөвшөөрнө.

3.7.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахилгаан шатны бүхээг нь опретортой холбогдох шуурхай гэмтлийн 2 талт утсан холбоо харилцаагаар хангагдсан байна. Цахилгаан шатыг дуудах болон түүний хөдөлгөөнийг удирдах товчлуур шалнаас дээш 1.2 м-ээс ихгүй өндөрт байвал зохино. Цахилгаан шатанд байрлаж буй 2 талт

холбооны аппарат нь дуу авиаг ихэсгэх төхөөрөмжөөр, шаардлагатай бол дуут (визуаль) мэдээллийг (дохиоллыг) хүлээн авах хэрэгслээр хангасан байх ёстой.

3.7.8. Тавцан хэлбэртэй өргөгчийг хэрэглэх үед шатны алхамын дагуу эсвэл хэвтээ, босоо чиглэлд шилжүүлэхэд тавцангийн өргөн 0.9 м-ээс багагүй, гүн нь 1.2 м-ээс багагүй байна.

3.7.9. Цахилгаан шатны гадна дотор товчлуурыг тэргэнцэртэй иргэнд зориулж 1 м-ээс ихгүй өндөрт байрлуулах ба хараагүй иргэнд зориулж брайл үсгээр давхар тоноггосон байна.

3.8. Ариун цэврийн өрөө

3.8.1. Олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөг төлөвлөнө. Хэмжээ нь 1.65 м-ээс багагүй өргөнтэй, 1.8 м-ээс багагүй урттай, хаалганы өргөн 0.9 м-ээс багагүй, босгогүй төлөвлөнө.

Тэргэнцрээс бие засах суултуурын нэг талаас шилжин суухад тохиромжтой хангалттай зайтай байна.

3.8.2. Таяг болон бусад хэрэгсэл ашиглаж явдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийтийн ариун цэврийн өрөөний 1-ээс багагүйд нь хажуугийн хананд бариул байрлуулна.

3.8.3. Ариун цэврийн өрөөний бие засах газарт 1 хөтөвчийг шалнаас 0.4 м-ээс ихгүй өндөрт, 2 талд нь босоо тулгуур бариул хийж өгнө.

3.8.4. Нийтийн ариун цэврийн өрөөний 1 угаалтуурыг шалны түвшинөөс дээш 0.8 м-ээс ихгүй өндөрт, хажуугийн хананаас 0.2 м-ээс багагүй зайд байрлуулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан толь ба гар хатаагчийг шалны түвшнээс дээш 0.8 м-ээс ихгүй өндөрт байрлуулна.

3.8.5. Нийтийн халуун усны газарт тэргэнцэртэй иргэнд зориулж нэг өрөөг төлөвлөнө. Шүршүүрийн бүхээгийн хэмжээ 1.2x0.9 м-ээс багагүй байна. Бүхээгийн өмнөх зайг тэргэнцэртэй иргэн орохоор бодолцож тооцно.

3.8.6. Шүршүүрийн бүхээгийн зохион байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн шүршүүрт орох, шүршүүрийн суудалд суух зэрэгт саадгүй байх шаардлагыг хангасан байна.

3.8.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөө болон өрөөний үүд хаалгыг гадагшаа онгойхоор төлөвлөнө.

3.8.8. Орон сууцны барилгын хувцасны өрөөний хэсгийн өргөн 1.2 м, урт нь 1.6 м-ээс багагүй байна.

3.9. Тоног төхөөрөмж, тоноглол

3.9.1. Явган зам, нийтийн эзэмшлийн газар, зам, гудамж, талбай, ялангуяа зөрлөг, цэцэрлэгт хүрээлэн, галт тэрэгний өртөө станц, нийтийн тээврийн зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд анхааруулсан түүнчлэн шаардлагатай тохиолдолд болзошгүй аюулын талаарх мэдээллийн хэрэгсэл байрлуулах хэрэгтэй.

3.9.2. Дуут дохио нь явган замын гадаргуу, болон шалны түвшнээс 1.5 м-ээс багагүй, 4.5 м-ээс ихгүй өндөрт эсрэг тод өнгийн дэвсгэр өнгөтэй байна.

3.9.3. Олон нийтийн, хүн их цуглардаг газарт дуут болон аялгуут мэдээллийн хэрэгсэлийг төлөвлөнө. Тээврийн хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохио нь хараагүй

болон харааны бэрхшээлтэй иргэдийг гарцаар гарах үед дуут дохио өгөх нэмэлт тоноглолоор тоноглогдсон байна.

3.9.4. Нийтийн эзэмшлийн газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан таксофоныг 1-ээс багагүйг эсвэл эгнээ болгонд 1-ийг шал, талбайн гадаргуугийн түвшнээс 0.8 м-ээс өндөргүй байрлуулна.

3.9.5. Шуудангийн хайрцгийг тэргэнцэртэй иргэн хүрч болох явган хүний зам ба шалнаас 1.3 м өндөрт байрлуулна.

3.9.6. Хүн амын үйлчилгээний цэг болох мухлаг, худалдааны лангуу, тасалбар түгээх цонх, бүртгэлийн газар, буфет, өлгүүрийн тавцанг явган хүний зам ба шалнаас 0.8 м-ээс ихгүй өндөрт байрлуулна.

3.9.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд үйлчлэх автомат тоног төхөөрөмж, билетийн автомат худалдааны тоноглол, цахилгааны залгуур, унтраалганы товч зэрэг хэрэгслүүдийг шал, явган хүний замын түвшингээс 1 м-ээс ихгүй өндөрт байрлуулсан байхаас гадна барилгын хажуугийн хананаас 0.4 м зайтай байна. Сэтгэцийн өвчтэй болон оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн дотуур байранд унтраалга, залгуурыг 1.8 м-ийн өндөрт төлөвлөх ба нэмэлт хамгаалах хэрэгслээр тоноглоно.

3.9.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслах хэрэгсэл болох таяг, алхагч хэрэглэдэг иргэнд зориулагдсан ариун цэврийн өрөөнд бариул, өргүүр, хашлага, тулгуур, татах татуурга зэрэг нэмэлт тоноглолуудыг хийх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэний шүршүүрийн өрөөнд түшлэгтэй сандал хийж өгнө. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие засах газарт хувцас, таяг өлгөх өлгүүр, тавиур зэрэг бусад шаардлагатай хэрэгсэлээр тоноглож өгнө.

3.9.9. Нийтийн бие засах хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн суултуур дээр суухад түүний хүрэх хэсэгт хонхны товч байрлуулана. Цахилгаан хонх болон дохио дамжуулагч нь бие засах хэсгийн ойролцоох жижүүрийн өрөөнд байрласан байна.

3.9.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглэх байнгын суурилуулсан тоноглолууд нь найдвартай бэхлэгдсэн байх ёстой. Тоноглолын бэхлэгээний зүйлс, унтраалгын хэсэг болон бусад зүйлүүд хана болон бэхлэгдэж байгаа тоноглолоос илүү гарах ёсгүй.

3.9.11. Сул буюу бүрэн хараагүй иргэн нэвтрэн орох шаардлагүй байр, өрөө рүү орох хаалганы бариул, цоож болон бусад хэсгүүд мэдэгдэхүйц ялгарах хээ дүрстэй барзгар гадаргуутай материалаар хийгдсэн байна.

3.9.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлчлүүлэх нийтийн үйлчилгээний барилга байгууламжийн орчин, тухайлбал: хувийн автомашины зогсоол, нийтийн тээврийн зогсоол, буудал, барилга байгууламж руу орох орц, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан аврах гарц, шилжих өрөө, нийтийн ариун цэврийн өрөө, халуун усны өрөөнүүд нь ялгах тэмдэг, тэмдэглэгээтэй байна.

3.9.13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьдарч ажиллах нийтийн байр, үйлдвэрийн газар, тусгай зориулагдсан байрны дотор автомат гал мэдрэх дохиоллоор тоноглох ёстой.

3.9.14. Орон сууц, олон нийтийн барилга, үйлдвэрийн газар, тусгай тоноглогдсон барилга дотор нэмэлт гэрлэн дуут дохио бүхий хоёрлосон дохиолол хийж өгөх ба эдгээр дохиолол нь иргэнд гал гарсан тухай мэдээлэх үүрэгтэй. Эсвэл стандартын нэмэлт залгуур тавьж өгөх ба энэ нь галын аюулыг мэдрэх дохиоллын системд холбогдсон байх шаардлагатай ба тэдгээр дохио өгөх багаж төхөөрөмжийг залгах боломжтой байна.

3.9.15. Харааны бэрхшээлтэй иргэнд зориулан тусгай барилга байгууламжийн хонгилын хананд шалнаас 1 м-ийн өндөрт тусгай хэлбэр гадаргуу бүхий тэмтрэх чиглүүлэгчийг хамгийн ойр байх аваарын гарцын чиглэлд хийж өгөх ёстой.

Дөрөв. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

4.1. Ерөнхий шаардлага

4.1.1. Орон сууц, олон нийт, үйлдвэрийн болон тээврийн барилга, байгууламжийн дотор, гадна орон зайд хөгжлийн бэрхшээлтэй, түүний дотор тэргэнцэр болон бусад туслах тоноглол хэрэгслийн тусламжтайгаар хөдөлж явдаг иргэн үйлчлүүлж ашиглах боломжийг хангасан төлөвлөлтийг зураг төсөлд тусгана.

4.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд зориулсан өрөө тасалгаануудыг (2-оос илүү) болон орон сууцны барилга, үйлдвэрийн газрыг галд тэсвэрлэлтийн зэрэг 2-оос доошгүй байхаар тооцож зураг төслийг боловсруулна. Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд зориулсан орон сууцны давхар 3-аас дээшгүй, харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчлэх байгууллагын барилга 2-оос дээшгүй давхар төлөвлөнө.

4.1.3. Олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн (сургалтыг дэмжих байгууллагуудыг хамруулаад), мөн нийтийн байрны зураг төслийг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан өрөө, байрыг нийт барилгын багтаамжийн 2 %-иас доошгүй, сувилалын болон амралт, аялал жуулчлалын байгууллагад 3 %-иас доошгүй байхаар тооцоолж төлөвлөнө.

4.1.4. Спортын болон үзвэрийн барилга, байгууламжид тэргэнцэртэй иргэдэд зориулсан заалны үзэгчдийн болон индэрийн суудлын тоог 300 суудал тутамд 1 суудал оногдохоор тооцоолно. Гэхдээ 1000 хүртэлх суудлын багтаамжтай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 4-өөс доошгүй суудал, харин 1000-аас дээш суудлын багтаамжтай байх тохиолдолд 20 суудал түүнчлэн 1000-аас дээш 100 суудал тутамд 1% нэмж төлөвлөнө.

4.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээлгэх болон тэдэнтэй уулзахад зориулж хонгилын хэсэгт тасалгаа төлөвлөж болох ба багтаамж нь 30 хүнээс илүүгүй байна. Харааны болон хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан барилгад байнга байх зориулалттай өрөөнөөс мухар хонгил руу гарах хаалга төлөвлөхгүй.

4.1.6. Тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашигладаг ганц бие болон гэр бүлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байр, тэдэнд зориулсан тусгай барилга байгууламж, нийтийн байрын доторх орон сууцны хэсэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байртай зочид буудлын өрөө ба сувилалын өрөө тасалгааг 1-р давхарт төлөвлөнө.

4.1.7. Тэргэнцэр ашигладаг иргэдийн байрны 1-р давхарт байх тагтнаас байрны хажуугийн ногоон байгууламж руу гарах гарц, налуу зам эсвэл өргүүр төлөвлөж болно.

4.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрны гал зуухны талбай 9м²-аас, өргөн нь 2,2 м-ээс багагүй байх ёстой.

4.1.9. Тэргэнцэр ашигладаг иргэдийн байрны эсвэл орон сууцны хэсгийн үүдний тасалгаанд, эсвэл үүдний өрөөний ойролцоо тэргэнцэр хадгалах зай, эсвэл жижиг агуулах байхаар бодолцоно.

4.1.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдрах зориулалттай сууцны дотор гэртээ ажиллахдаа ашигладаг багаж хэрэгсэл, материал болон эдлэл хадгалахад зориулсан жижиг

агуулахыг зураг төсөлд тусган төлөвлөж болно. Уг агуулахын талбай нь 4 м²-аас багагүй байна.

4.1.11. Орон сууцны барилга дотор нэмж эсвэл өргөтгөж барьсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд үйлчлэх соёл-ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ явуулах тасалгааг 2-оос дээшгүй давхарт төлөвлөх ёстой.

4.1.12. Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага, спортын зориулалттай барилга, байгууламжид эмчийн өрөө 16 м²-аас багагүй, иллэгийн ор тус бүр 16 м²-аас багагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хувцас солих өрөөг 6 м²-аас багагүй талбайг төлөвлөнө.

4.1.13. Нийтийн барилга, байгууламжийн үүдний танхим болон хувцасны өлгүүрийн зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дагалдаж яваа иргэнд зориулсан зайг хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус бүрт 0.5 м²-аас багагүй байхаар төлөвлөнө.

4.1.14. Тусгай зориулалттай орон сууцны барилгын болон нийгмийн үйлчилгээний төвийн зураг төслийг 1.4 м–ээс багагүй гүнтэй тагттай байхаар төлөвлөнө.

4.1.15. Үзвэрийн танхимд сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай сонсголын аппаратаар тоноглогдсон 3-аас доошгүй үзэгчийн суудлыг 1-3-р эгнээнд төлөвлөнө. Тэргэнцэртэй иргэдийн суудлыг 1 эгнээнд 3-аас илүү байрлуулах шаардлагагүй.

4.1.16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настныг нээлттэй ил төмөр шатаар нүүлгэн шилжүүлэх арга хэрэглэж болохгүй.

Тав. СПОРТЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

5.1 Ерөнхий шаардлага

5.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан биеийн тамир-эрүүлжүүлэх дасгал сургууль хийх заал тасалгааг өөр зориулалттай барилгын дотор оруулж эсвэл нийлүүлж барьсан спортын заал, тусдаа байгаа барилгын бүтцэд оруулж төлөвлөж болно. Хараагаа бүрэн буюу хагас алдсан иргэний дасгал сургуулийг дуу авианы тусгаарлалт (дуу тусгаарлагчгүй) хангахгүй хаалт, хамар ханатай тусгаар талбай, бүс олон секцтэй заалуудад хийхийг хориглоно. Эдгээр иргэдэд зориулсан биеийн тамирын заалыг дуу шингээдэг таазтай, хананд шалнаас 2 м-ээс багагүй өндөрт хамгаалалтын зөөлөн бүрээс хийж ханын дагуу чиглэлд бариулыг тогтооно.

5.1.2. Үзэгчдийн суудал талаас гүйлтийн замын дагуу өргөнөөрөө 1 м-ээс багагүй аюулгүйн зурвас, харин түүний цаана тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байрлуулах 3 м–ээс багагүй өргөнтэй чөлөөтэй хэсэг байхаар төлөвлөнө.

5.1.3. Тэргэнцэртэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэний дасгал сургууль хийх талбай, бүсийн эргэн тойрон 2 м-ээс багагүй өргөнтэй, тоглолтын талбайн богино талаар 3 м-ээс багагүй өргөнтэй аюулгүйн зурвас тогтооно. Одон бөмбөгийн талбар дээр талбайн дагуу 4 м хүртэл, богино талын дагуу 6 м хүртэл аюулгүйн бүсийг нэмэгдүүлэнэ.

5.1.4. Хэрэв гүйлтийн зам үзэгчийн суудлаас хаалтаар тусгаарлагдсан байвал хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж хоорондоо 100 м-с багагүй зайд гарц зам төлөвлөнө.

5.1.5. Харааны бэрхшээлтэй болон сул хараатай тамирчны явах чиг баримжаа болон аюулгүй байдлыг хангаж өгөхийн тулд :

- хөдөлгөөний чиглэл чиг баримжаа өгөх зориулалтаар дуу авиа бүхий гэрэлт цамхагийг ашиглах
 - тоглолтын талбайн периметрээр (эргэн тойронд) өргөнөөрөө 1.5 м-ээс багагүй чиг баримжааны зурвас, түүнтэй нийлүүлж өргөнөөрөө 2.5 м-ээс багагүй аюулгүйн зурвас тогтоох
 - гүйлтийн эсвэл харайхын өмнөх гүйлтийн замын дагуу өргөнөөрөө 2 м-ээс багагүй чиг баримжааны зурвас тогтоох
 - гүйлтийн зам дээр хөдөлгөөний дагуу чиглэлд 5м-ээс багагүй урттай гарааны бүс (талбай) болон 25 м-ээс багагүй урттай барианы бүсийг (талбайг) урьдчилан тогтооно.
 - хиймэл усан сан, усанд орох онгоцны (ванны), эргэн тойрны дагуу өргөнөөрөө 1,2 м-ээс багагүй чиг баримжааны зурвас байрлуулах
 - чиг баримжааны зурвас болон гүйлтийн замын эргэлтүүд, гараа барианы бүс, үсрэхэд түлхэлт авах талбай зэргийг тод өнгөтэй онцлог гадаргуугаар ялгаж харагдахаар төлөвлөнө.
- 5.1.6. Харааны бэрхшээлтэй болон сул хараатай иргэний дасгал сургуульд зориулагдсан задгай талбай, байгууламж бүхий бүсийг дуу шуугианаас хамгаалахдаа зуны улиралд нийлбэр тооцооны дагуу 3 дБ-ээс доошгүй түвшинд барьж чадах ногоон байгууламж төлөвлөнө.
- 5.1.7. Халуун усны ууранд орох өрөө (саун)-г тусдаа байгаа барилга дотор эсвэл галд тэсвэрлэлтийн зэрэг 2-оос багагүй барилгын нэгдүгээр давхарт байрлахаар өрөө тасалгааг нь төлөвлөж галын аюулын эсрэг нормын шаардлагуудыг баримтлах ёстой.

5.2. Усан сан

5.2.1. Усан сангийн эргэн тойронд доорхи хэмжээнээс багагүй өргөнтэй тойруу замыг төлөвлөнө:

- задгай /ил/ усан сангийн хувьд – 2.5 м
- заалан доторх усан сангийн хувьд – 2 м

Гарааны тавцан болон хувцас солих өрөөнөөс усан сан руу гарч ирэх хаалга талын замын өргөн 3.5 м-ээс доошгүй байх.

5.2.2. Усан сангийн заалын ханын дагуу, хувцас солих өрөө ба шүршүүрийн өрөөнөөс заал руу орох хаалганы хэсэгт шалнаас 0.9–1.2 м-т, харин хүүхдэд зориулсан усан сангийн зааланд шалнаас 0.5 м өндөрт хана дагуулан хөндлөн бариул суурилуулна.

5.2.3. Ил (задгай) усан сангийн тойруу замын дагуу бариултай, 1 м-ээс доошгүй өндөртэй хашлага байхаар төлөвлөнө.

5.2.4. Усан сангийн гүехэн хэсэгт ус руу буухад зориулсан өргөнөөрөө 0,9м-ээс багагүй, гишгүүр нь 0.3 м-ээс багагүй өргөнтэй, гишгүүрийн өндөр нь 0,14 м-ээс илүүгүй шат суурилуулах хэрэгтэй. Шат нь хөдөлгөөнгүй бариултай байна.

5.2.5. Хүүхдүүдэд зориулсан усан сангийн усанд орох онгоцны хэмжээ нь доорхи хэмжээнээс багагүй байх ёстой:

- сургуулийн өмнөх байгууллага, дотуур байранд – 3х7 м
- дотуур байртай сургуульд – 6х12.5 м.

Усан сангийн гүнийг усны түвшин солигдохоор тооцоно:

- сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд 0.6 м-0.8 м
- сургуулийн насны хүүхдүүдэд 0.8 м-1.05 м
- дотуур байрны хүүхдүүдэд 0.25 м-0.5 м

5.2.6. Тулгуур эрхтэний хөдөлгөөний бэрхшээлтэй иргэнийг ус руу буулгах болон уснаас гаргахдаа усны жижиг онгоц юм уу тусгай өргөгчийг ашиглана.

5.3 Туслах өрөө, тасалгаа

5.3.1. Хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хувцас солих өрөөнд дараах орон зайг урьдчилан төлөвлөнө:

- тэргэнцрүүдийг хадгалах байр:
- хувцас солиход зориулсан тэргэнцэртэй 3 хүний дунд 1 өрөөг тус бүр 4 м²-ээс багагүй талбайтай байхаар тооцно.
- таяг болон хиймэл эрхтэн /протез/ хадгалах:
- хүн бүрт зориулж 2-оос цөөнгүй шүүгээг 1.7 м-ээс илүүгүй өндөртэй төлөвлөнө. Хувцасны өрөөнд урт нь 3 м, өргөн нь 0.7 м-ээс багагүй, 0.5 м-ээс илүүгүй өндөртэй урт сандал, тэргэнцэртэйгээ сандалд ойртоход нь зориулж сандалын эргэн тойрны орчинг чөлөөтэй байлгана. Тухайн заасан урт сандалыг суурилуулах боломжгүй тохиолдолд аль нэг хананы дагуу 0.6 м-ээс доошгүй өргөнтэй урт сандалыг байршуулна.

5.3.2. Тэргэнцэртэй иргэн болон тэдгээрийг дагалдаж яваа иргэнд зориулсан хувцас солих өрөө нь тус бүр 14 м² талбайтай 2 давхарласан 3 ш хувцасны шүүгээ, тус тусын шүршүүр, бие засах өрөөтэй 2-оос цөөнгүй блок байхаар урьдчилан тооцож зураг төсөлд тусгана. Спортын барилга, байгууламж нь 35 тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нэвтрүүлэх чадамжтай гэж тооцвол дээрх блок 4-өөс цөөнгүй байх ёстой.

5.3.3. Тэргэнцэртэй иргэдийн тус бүрийн хувцас хадгалах шүүгээг доод хэсэгт байрлуулах нь зохимжтой. Гэрийн хувцасыг ил өлгөх тохиолдолд өлгүүрийг шалнаас 1.3 м-ээс илүүгүй өндөрт тогтооно.

5.3.4. Хувцас солих өрөөнөөс усан сан руу явах замд буй хөл угаалгын хэсгээр тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн дайрч өнгөрөх боломжийг бодолцож, төлөвлөлт хийнэ.

5.3.5. Хичээллэж буй тэргэнцэртэй иргэн бүрт хувцасны өрөөнд 0.4 м²; саунд 20 м²-аас доошгүй талбайтай амралтын өрөө байхаар тооцно.

Зургаа. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

6.1. Орон сууцны барилга

6.1.1. Орон сууцны барилгын сууцны өрөө тасалгаа нь 25 хүнээс ихгүй багтаамжтай байхаар төлөвлөнө.

6.1.2. Орон сууцны барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд зориулсан соёл-ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээний өрөө, тасалгааг төлөвлөнө. Орон сууцны барилгын цогцолборт эрүүл мэндийн, нийгмийн ба мэргэжлийн сэргээн засалтын мэргэшсэн төвүүд болон уг байгууллагуудад зориулсан сургалт-үйлдвэрлэлийн зориулалттай тасалгааг нэгтгэн орон сууцны барилгын бүрэлдэхүүнд эсвэл дотор нь багтаан мөн нийлүүлж, тусдаа бие даасан халаалтын нэгдсэн системд холбогдсон орон сууцны хэсэгт төлөвлөнө.

6.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд үйлчлэхэд зориулж дотуур байр, орон сууцны хэсэг бүрт үйлчлэх зорилгоор доорх өрөө тасалгааг заагдсан талбайн хэмжээнээс багагүй төлөвлөнө. Үүнд:

- Угаалгын өрөө – 12
 - Бие засах өрөө – 4.5
 - Шүршүүртэй бүхээг – 3 (хувцас солих хэсгийн хамт)
 - Ариун цэврийн өрөө – 16
- Аж ахуй хэрэглээнд зориулсан өрөө – 12, цэвэр болон бохир цагаан хэрэглэлийн агуулах зэрэг байна.

Үүнээс гадна сууцны бүтцэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд зориулсан өөрөө өөртөө үйлчлэх боломжтой нийтийн өрөөг тооцож төлөвлөнө. Уг өрөөний талбайг 1 хүнд 1.2 м²-аас багагүй мөн буфет-гал зуухны өрөөний талбайг 1 хүнд 0.6 м²-аас багагүй байхаар тооцно.

6.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд зориулсан дотуур байранд 4 м²-аас доошгүй талбайтай өрөөг эмнэлгийн дугуйтай дамнуурга, тэргэнцрийг хадгалахад зориулж төлөвлөнө.

6.1.5. Сэтгэцийн өвчтэй өвчтөнд зориулсан дотуур байранд дараах тасгийг төлөвлөнө. Өвчтөнг чөлөөтэй байлгахын тулд сэргээн засах-ажиглах эмчилгээ болон сэргээх засах-хэвтрийн байдалд байнгын асран сувилах чиглэлийн тасгууд болно.

6.1.6. Сэтгэц мэдрэлийн тусгаар барилгын хооллох өрөөний дэргэд нэг суудалд 0.25 м²-аас багагүй хэмжээтэй талбай оногдохоор тооцож хувцасны өлгүүр бүхий хөлийн өрөөг төлөвлөнө.

6.1.7. Галын аюулын эсрэг орон сууцны өрөө тасалгааг тусгаарласан болон хонгилын хана, шатахад хялбар материал хадгалах, дахин боловсруулах өрөөний агуулах, дадлагын өрөөний хана, хамар хананд галын аюулын эсрэг 2-р төрлийн хаалга төлөвлөнө.

6.2. Нийгмийн үйлчилгээний нутаг дэвсгэрийн төв

6.2.1. Нийгмийн үйлчилгээний нутаг дэвсгэрийн төв нь үндсэн хоёр төрөл байна. Өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дотуур байранд өдрийн цагаар гэрийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн төв, тасгуудыг төлөвлөх эсвэл мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд (эрүүл мэнд, нийгэм, мэргэжлийн сэргээн засалт)-ын тасаг, хэсэг албаны салбарыг нэгтгэсэн бүс нутгийн төв байж болно.

6.2.2. Нийгмийн үйлчилгээний бүс нутгийн бие даасан төв түүний салбаруудад эсвэл орон сууцны зориулалтаар баригдсан байранд амьдарч буй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 30-аас багагүй хувь нь нийгмийн бүрэн үйлчилгээнд хамрагдахаар тооцож төлөвлөлт хийнэ.

6.2.3. Нийгмийн үйлчилгээний бүс нутгийн төвд, нийтийн орон сууцанд ерөнхий эмчилгээний болон бүртгэл мэдээлэл лавлагааны зориулалттай доорх өрөөнүүдийг заагдсан талбайгаас багагүй хэмжээгээр төлөвлөнө.

- хоёр төрлийн үйл ажиллагааны зориулалттай өрөө, (тус бүр)–12 м²-аас багагүй
- ороох боох материалын өрөө – 22 м²-аас
- гурван кабинет, (тус бүр) – 18 м²-аас
- лабораторийн өрөө – 14 м²-аас (нийт талбай)
- хоёр өрөө, (тус бүр) – 12 м²-аас (хиймэл эрхтэний хэв авах, тааруулах тоноглол мөн цэвэр, бохир цагаан хэрэглэлүүдийг хадгалах тусгай шүүгээ, жижиг агуулах)

6.2.4. Сургалт үйлдвэрлэлийн анги болон ур чадварын дадал олгох байрыг өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний байнга зорчих хэсэг, галын аюулгүйн шаардлага, байруудын байршсан чиглэл зэргийг харгалзан тус тусад нь блокчлох юм уу эсвэл нэг эгнээнд байршуулна.

6.2.5. Өдрийн цагаар ашиглах зориулалттай дор дурьдсан өрөөнүүд заагдсан талбайн хэмжээнээс багагүй байна:

- хувцасны өлгүүрийн өрөө – 15 м²-аас
- өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээж авах өрөө (тус бүр) – 36 м²-аас
- өдөр амрах зориулалттай өрөө (тус бүр) – 16 м²-аас
- гал тогоо, буфет – 9 м²-аас
- шүршүүртэй хувцас солих өрөө

6.2.6. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй нэг бүлэг иргэнд зориулсан өрөөний багтаамж 25 хүнээс илүүгүй хүн багтахаар тооцож барилгын нэгдүгээр давхарт байхаар төлөвлөнө. Өдрийн цагаар үйлчлүүлэхэд зориулагдсан өрөөнүүдийг 2-оос дээш давхарт төлөвлөх бол цахилгаан шат төлөвлөнө.

6.2.7. Гэрийн үйлчилгээний тасаг болон төв хяналтын цэг, албан ажилтаны өрөө, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын жижиг агуулах болон цэвэр, бохир цагаан хэрэглэлд зориулсан шүүгээнүүдийг байрлуулахаар тооцно.

Долоо. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ СЭРГЭЭН ЗАСАХ БАЙГУУЛЛАГА

7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах тусгай байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьдарч буй газарт болон сувилалын байгууллагын харьяанд эмнэлгийн, нийгмийн, мэргэжлийн сэргээн засах төвийг төлөвлөх ёстой.

7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай байгууллагуудын бүрэлдэхүүнд хиймэл эрхтэн ба тэргэнцэр засварлах ажлын байр, тэргэнцрүүдийг хадгалах өрөө, мэргэжлийн сэргээн засалтанд зориулсан өрөөг урьдчилан бэлтгэнэ.

Амьдрах өрөө нь сургалт үйлдвэрлэлийн зориулалттай өрөөнөөс галаас хамгаалах 3-р төрлийн хучилт хийцээр тусгаарлагдана.

7.3. Тусгай зориулалттай төвийг төлөвлөхдөө эмнэлгийн, нийгмийн болон мэргэжлийн сэргээн засалтын зориулалттай байгууллагуудад үндсэн бүлэг өрөөнүүдийг төлөвлөх хэрэгтэй. Үүнд:

- биеийн тамирын дасгалаар эрүүлжүүлэх арга хэмжээнд зориулсан өрөө
- эмнэлгийн зориулалттай өрөө
- ахуй- албаны зориулалттай өрөө

7.4. Хөдөлгөөний эмчилгээгээр сэргээн засал хийх өрөөний бүлэгт дараах өрөө орно.

Үүнд:

- биеийн хөдөлгөөний ерөнхий дасгал хийх, хөдөлгөөн эмчилгээ хийх, тоглоомын зориулалттай спортын танхим
- дасгалжуулах заал
- усан эмчилгээ болон гар заслын эмчилгээ
- иллэг хийх танхим
- ахуй заслын танхим
- хэл заслын танхим

- халуун ус-ууранд ороход зориулагдсан туслах өрөө тасалгаа бүхий усанд сэлэх усан санг урьдчилан тооцно.

7.5. Эмчилгээний зориулалттай өрөөний бүрэлдэхүүнд цахилгаан, гэрлэн эмчилгээний кабинет, дулаанаар эмчлэх эмчилгээний кабинет, эмчийн кабинеттай эмчилгээний өрөө, сэтгэл зүй, дадал зуршлын эмчилгээний өрөө, кабинетууд орно.

Цахилгаан ба гэрлэн эмчилгээний кабинетийн шал бүхэлдээ цахилгаан тусгаарлагч материалаар хийгдсэн байх ёстой. Кабинетийн ханын өнгөлгөө керамик хавтанцар бүхий материалаар хийгдсэн байж болохгүй.

7.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай сувиллын газруудад нийтийн зориулалттай өрөөнөөс гадна сувилалын бүх төрөлд зориулсан дараах өрөө багтана. Үүнд: дурангийн кабинет, оношилгоо хийх бүрэлдэхүүнд ходоодны шүүс оношлох кабинет, булчингийн үйл ажиллагааг сэргээх болон ходоод гэдэсний эмчилгээний кабинет, физик эмчилгээний тасаг түүнчлэн нян судлал болон шавар эмчилгээ, бөөрний эмч нарын кабинетуудыг заавал төлөвлөнө.

7.7. Орон сууцны бүтцэд багтаан хөдөлгөөн засал хийх, явган явж сургах болон иллэг хийх кабинетуудыг төлөвлөнө.

7.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сувиллын газрын өрөөний талбай 1 хүнд 11 м², 2 хүнд 16 м²–аас багагүй байна. Орон сууцны өрөөнд үүдний хэсгийн талбай ба ариун цэврийн өрөөний талбай 4.5 м² –аас багагүй байна.

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах кабинетыг барилга байгууламжийн нэгдүгээр давхарт төлөвлөнө. Хэрэв хоёроос дээш давхарт төлөвлөхөөр бол цахилгаан шат болон өргөх төхөөрөмжийг төлөвлөнө.

Найм. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГА

8.1. Ерөнхий шаардлага

8.1.1. Хараа, сонсголын болон оюун ухаан, хэл ярианы бэрхшээлтэй, ортопедийн туслах хэрэгсэл хэрэглэдэг хүүхдэд үйлчлэх тусгай зориулалттай байгууллагын бүтцэд дараах бүлэг өрөө орно. Үүнд:

- хүүхдийн амьдрах өрөө
- биеийн тамир, хөгжмийн ба тусгай хичээл заах өрөө
- эмнэлгийн үйлчилгээ
- хооллох газар
- албаны болон аж ахуйн зориулалттай өрөө зэрэг болно

8.1.2. Сурагчдын дотуур байр, дотуур байртай сургуулийн барилгад сургалтын болон сургалт үйлдвэрлэлийн дадлагын өрөөг төлөвлөнө.

8.1.3. Хүүхдэд үйлчлэх тусгай байгууллагад цагаан хэрэглэл угаах өрөөг зайлшгүй төлөвлөнө. Угаалгын газрыг хоёр ээлжээр ажиллахаар тооцож 1 сурагчид өдөрт 1 кг-аас багагүй хуурай цагаан хэрэглэл, хэвтэрт байгаа сурагчид 2 кг-аас багагүй цагаан хэрэглэлээр хангах хүчин чадалтай байхаар төлөвлөнө.

8.2. Хүүхдүүдийн амьдрахад зориулсан өрөө

8.2.1. Хүүхдүүдийн амьдрахад зориулсан бүлэг өрөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- бүлгээрээ хамт байх өрөө – сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан
- сурч амьдрах өрөө – сургуулийн бага насны хүүхдэд зориулсан
- амьдрах сууцны өрөө – дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан дотуур байртай сургуульд, дотуур байранд

8.2.2. Амьдрах болон сурч амьдрах хэсэгт дараах өрөөнүүд багтах ба 1 сурагчид оногдох талбай доор зааснаас багагүй байна:

- унтлагын өрөө – 4 м²-аас багагүй
- хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сууцны өрөө – 6 м²ээс багагүй
- өдөр өнжүүлэх өрөө – 3 м²-аас багагүй
- сурч амьдрах зориулалттай хэсгийн ангийн өрөө – 2. м²-аас багагүй
- хувцасны өлгүүрийн өрөө – 1 м²-аас багагүй
- оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан буфет -0.5м²-аас багагүй,
- эмчилгээ, эрүүл ахуйн өрөөнүүд – 1 м²-аас багагүй
- хувцас хатаах өрөө – 0.35 м²-аас багагүй

Хүүхдүүдийн хувийн эд зүйлсийг хадгалах жижиг агуулах бүхий жижүүр багшийн өрөө – 0.5 м²-аас багагүй

Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын бүлэг өрөө тасалгааны хэмжээ бүтцийг "Олон нийт, иргэний барилга" БНБД /31-03-03/-ын шаардлагыг харгалзан тогтооно.

8.2.3. Дотуур байртай сургуулийн ахлах ангийн хүүхдүүдэд зориулж сууцны хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дасгал сургууль хийх өрөөг 1 сурагчид 1.5 м²–аас багагүй талбай ноогдохоор тооцно. Нуруу нугас, тархины саажилттай хүүхдүүдэд зориулж 1 сурагчид 1.8 м²-аас багагүй талбайтай өрөөнүүдийг нэмж төлөвлөнө.

8.3. Сургалтын болон сургалт үйлдвэрлэлийн өрөө

8.3.1. Дотуур байртай сургуульд дараах өрөөг төлөвлөнө.

- Сургалтын кабинет
Талбайг нь сонголын ба оюун ухааны хомсдолтой 1 сурагч тугамд 2.5 м²–аас багагүй, нуруу нугас, тархины саажилттай 1 хүүхдэд 3 м²-аас багагүй талбай ноогдохоор тооцож төлөвлөнө.

- Сургалтын лаборатори
Талбайн хэмжээ нь хараа ба оюун ухааны хомсдолтой сурагч тус бүрт 3 м²–аас багагүй тархи, нуруу нугасны саажилттай 1 сурагчид 3.5 м²-аас багагүй талбай ноогдохоор тооцно.

Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан баримал болон дүрс зургийн сургалтын кабинетын талбайн хэмжээ хүүхэд тус бүрт 4 м²–аас багагүй байна.

8.3.2. Сургалтын кабинет болон лабораторид лаборантын өрөө нь 18 м²-аас багагүй талбайтай байна.

8.3.3. Дунд болон бага насны сургуулийн хүүхдүүдэд зориулсан амралт, тоглоомын өрөөг хүүхэд тус бүрт 1.2 м²-аас багагүй талбай оногдохоор тооцож төлөвлөнө.

Сургуулийн бага насны хүүхдэд зориулж сургалт-сууцны хэсэгт амралт тоглоомын өрөөг өдрийн цагаар ашиглахаар төлөвлөнө.

8.3.4. Сургалт үйлдвэрлэлийн дадлага, ажлын ур чадварын дадал олгох хэсэгт доорх өрөө, тасалгаа орно. Үүнд:

- сургуулийн бага насны хүүхдүүдэд зориулсан дадлагын газар. 1 ажлын байранд оногдох талбайн хэмжээгээр тодорхойлно. Тухайлбал, сонсголын болон оюун ухааны хомсдолтой хүүхдүүдэд 2 м²–аас, харааны болон нуруу нугас, тархины саажилттай хүүхдүүдэд 2,5 м²–аас багагүй талбай ноогдоно.
 - ахлах болон дунд сургуулийн хүүхдүүдэд зориулсан дадлагын газар. Ажлын байрны талбайн хэмжээ оюун санааны болон сонсголын бэрхшээлтэй 1 хүүхдэд 5 м²-аас багагүй, харааны болон нуруу нугас, тархины саажилттай 1 хүүхдэд 5,5 м²-аас багагүй байна.
 - хөдөлмөрлөх дадал олгоход зориулсан газар. Энэ нь ажил хөдөлмөр гүйцэтгэх технологийн шаардлагуудтай уялдуулан төлөвлөгдсөн ажил зохион байгуулагчийн кабинет, агуулахын өрөөнүүдтэй байна.
- Дээр дурдсан өрөөнүүдийг (дадлагын газруудыг) тусгаар блокод нэгтгэн, дотуур байртай сургууль эсвэл асрамжийн байртай зэрэгцүүлэн байршуулж сургалтын ба сууцны өрөө тасалгаануудтай төвөггүй холбогдсон, эдэлбэр газар руу шууд гарах гарцтай төлөвлөнө.

8.3.5. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагад:

- 4-н бүлэг сууц бүрт эсвэл сургалт-сууц бүхий нэг хэсэгт хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд зориулан 12 м²–аас багагүй талбайтай хэл заслын 1 танхим
- хүүхдийн дадлагын сургалтанд зориулсан 24 м² –аас багагүй талбайтай өрөөг тус тус төлөвлөнө.

8.4. Биеийн тамир, дуу хөгжим, тусгай хичээлийн өрөө

8.4.1. Дотуур байртай сургуульд биеийн тамир, дуу хөгжим, айзам хэмнэлийн дасгалын заал, усан санг төлөвлөх ёстой.

8.4.2. Дотуур байр, сургуульд дугуйлан хичээллэх өрөө, кино гаргах тайзтай тусгай заал, номын сангийн өрөөг төлөвлөнө. Олон нийтийн заалын хэмжээг хүүхэд бүрт 0.8 м²–аас багагүй талбай оногдохоор тооцож нийт хүүхдийн 75%-аас багагүйг багтаахаар тооцно.

8.5. Эмнэлгийн сэргээн засалтын өрөө

8.5.1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагад хүүхдийг эмнэлгийн сэргээн засалтын үйлчилгээгээр хангахад зориулж эмчийн өрөө, хөдөлгөөн заслын өрөө, ахуй заслын өрөө, хэл заслын өрөө төлөвлөнө.

8.5.2. Дотуур байртай сургууль, асрамжийн байранд эмнэлгийн үйлчилгээний дараах өрөөг төлөвлөнө. Эдгээрт; эмч, зөвлөх эмчийн өрөө, хүлээн авах тасаг, тусгаарлах өрөө, ахлах сувилагчийн өрөө, дотрын кабинет, сэргээн засах эмчилгээний өрөө, ерөнхий эмчилгээний лаборатори, эмийн сан орно.

8.5.3. Тусгаарлах тасагт 30 хүүхэд багтхаар төлөвлөнө. Тусгаарлах хэсгийн өрөө болон тусгаарлагч өрөөг ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагаар барилгын 1-р давхарт тусдаа орцтой төлөвлөнө.

8.5.4. Тусгаарлах хэсгийн өрөөний багтаамж нь сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагад 1 байранд 50 хүүхэд, дотуур байртай сургуульд 20 хүүхэд хүлээн авахаар тооцно. Тусгаарлах тасаг нь 1 сурагчид 6 м²–аас багагүй талбайтай 1-2 ортой төлөвлөнө. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын эмнэлгийн өрөөг тусгаарлахдаа хонгилоос орох тусгай орцтой төлөвлөх ба уг орц тусгаарлах тасгуудын нэгтэй нь зэрэгцээ төлөвлөнө.

8.6. Хооллох байр

8.6.1. Сургууль ба асрамжийн хооллох байрны бүтцэд хүүхэд болон багш нарт зориулсан тус тусын хооллох заал, үйлдвэрлэлийн, захиргаа аж ахуйн, агуулахын зориулалттай өрөө, тасалгаанууд орно.

8.6.2. Дотуур байртай сургуулийн хооллох зааланд нийт сурагчдын 70%-аас багагүйг хамрахаар тооцож, 1 суудлын талбайн хэмжээг харааны бэрхшээлтэй болон нуруу нугас, тархины саажилттай хүүхдэд 1,6 м²–аас багагүй, оюун ухаан, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд 1,3 м² –аас багагүй талбай оногдохоор тооцно. Дээрх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь зөвхөн бие дааж явах чадвартай тохиолдолд тэднийг нэг ээлжинд хооллохоор зохион байгуулж тооцох хэрэгтэй.

Хавсралт 1



Налуу замын явалтын урт нь түүний налуугийн хэмжээнээс хамаарах нь.

Хавсралт 2



Мушгиа налуу замын радиус, налуугийн хэмжээ 2-ын хамаарал

ГАРЧИГ

Хуудас

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	
1.1. Хэрэглэх хүрээ	3
1.2. Иш татсан баримт бичгүүд	3
1.3. Нэр томьёо	3-4
2. ХҮН АМ ОРШИН СУУХ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ	
2.1. Ерөнхий шаардлага	4-
2.2. Нугаг дэвсгэрийн хэмжээ	5-6
3. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОРЧНЫ ҮНДСЭН ЭЛЕМЕНТ	
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зай	6-7
3.2. Явган хүний зам	7

3.3. Явган хүний зам болон шал, түүний гадаргуу	7-8
3.4. Авто машины зогсоол	8
3.5. Шат ба налуу зам	8-9
3.6. Барилга, байгууламжийн орц	9-10
3.7. Цахилгаан шат	10-11
3.8. Ариун цэврийн өрөө	11-12
3.9. Тоног төхөөрөмж, тоноглол	12-13
4. БАРИЛГА БА БАЙГУУЛАМЖ	
4.1. Ерөнхий шаардлага.....	13-14
5. СПОРТЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	
5.1. Ерөнхий шаардлага	15-16
5.2. Усан сан	16-17
5.3. Туслах өрөө, тасалгаа	17-18
6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ЗОРИУЛСАН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	
6.1. Орон сууцны барилга	18-19
6.2. Нийгмийн үйлчилгээний нутаг дэвгэрийн төв	19-20
7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ СЭРГЭЭН ЗАСАХ БАЙГУУЛЛАГА	20-
	21
8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГА	
8.1. Ерөнхий шаардлага	21
8.2. Хүүхдүүдийн амьдрахад зориулсан өрөө	21-22
8.3. Сургалтын болон сургалт үйлдвэрлэлийн өрөө	22-23
8.4. Биеийн тамир, дуу хөгжим, тусгай хичээлийн өрөө	23
8.5. Эмнэлгийн сэргээн засалтын өрөө	23-24
8.6. Хооллох байр	24
ХАВСРАЛТ 1, ХАВСРАЛТ 2	
.....	25